



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 07 сарын 21 өдөр

Дугаар 1/56

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудлын үйл
ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
олгох, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Атар шим трейд ХХК-ийн “Тэргэл” зочид буудлын 19/295, Атар шим трейд ХХК-ийн “Тэргэл-2” зочид буудлын 19/293, Амар шим трейд ХХК-ийн “Тэргэл-3” зочид буудлын 19/292, Ева центр ХХК-ийн “Ион” зочид буудлын 19/295, Мөнххаан мөнх ХХК-ийн “Мөнххаан” зочид буудлын 19/230, Тайж өргөө од ХХК-ийн “Тайж” зочид буудлын 19/246, Блюскай эйжиа ХХК-ийн “Блю Скай тауэр” зочид буудлын 19/280, Алс тэртээ ХХК-ийн “Топаз” дэн буудлын 19/254 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.


4. Зөвшөөрөл авсан байгууллагуудтай гэрээ байгуулж, үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

1150500142

5. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Үйлчилгээний чанар, стандарт хариуцсан мэргэжилтэн /Ч.Энх-Отгон/-д үүрэг болгосугай.

6. Зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдээс гэрчилгээний үнийн 5,000 /таван мянга/ төгрөгийг Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцоож/-д даалгасугай.

ДАРГА



С.БАТБААТАР

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2020 оны 07 сарын
21-ний өдрийн А/56 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

5284325 СБТ-8936 1118263502

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2020 оны 07 дугаар сарын 21-ний өдөр

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Атар шим трейд ХХК	2595435	Тэргэл	БЗД-ийн, 7-р хороо, Б.Доржийн гудамж 11
2	Атар шим трейд ХХК	2595435	Тэргэл-2	БГД-ийн, 7-р хороо, Ард Аюушийн өргөн чөлөө 65/5
3	Атар шим трейд ХХК	2595435	Тэргэл-3	БГД-ийн, 9-р хороо, Хасбаатарын гудамж 25/2
4	Блюскай эйжиа ХХК	5093171	Блю Скай тауэр	СБД-ийн, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 17
5	Мөнххаан мөнх ХХК	5500435	Мөнххаан	БГД-ийн, 4-р хороо, Замчдын гудамж 7-3 тоот
6	Тайж өргөө од ХХК	6313841	Тайж	БЗД-ийн, 7-р хороо, Б.Доржийн гудамж 3 тоот

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2020 оны 07 сарын
21-ний өдрийн А/56 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

5284025 СБТ 8936 1118203602

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2020 оны 07 дугаар сарын 21-ний өдөр

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Ева центр ХХК	2667037	Ион	БЗД-ийн, 14-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 190
2	Урсгал хайрхан гол ХХК	6534538	Урсгал хайрхан гол	БГД-ийн, 9-р хороо, Хасбаатарын гудамж 23-5 тоот
3	Алс тэртээ ХХК	5392098	Топаз	БЗД-ийн, 13-р хороо, Дүүргийн 4-177 тоот

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР